98

# БНМАУ

## УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 12 сарын 23 №356. Улаанбаатар хот

"Автобус-3 компани /УҮГ/ байгуулах тухай

Хөдөлмөрчдийн үйлчилгээнд автобусны үйлчилгээ хүрэлцэхгүй байгааг харгалзан БНМАУ-ын Аж ахуйн нэгжийн хуулийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1.Авто тээврийн 30-р баазыг татан буулгаж "Автобус-3" компани /УҮГ/ болгон өөрчилж зохион байгуулсугай.

2."Автобус-3" компани /УҮГ/-ыг дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3.Компанийн дүрмийн санг 6,4 сая төгрөгөөр тогтоосугай.

4.Хувьчлагдаж байгаа авто баазуудаас автобус, РАФ маркийн автомашинуудыг "Автобус-3" компанид балансаас балансад шилжүүлж байхыг өмч хувьчлалын комисс /н.Ганхуяг/-т зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ц.БОЛДСАЙХАН

Улаанбаатар хотын Ардын хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 256 тоот тогтоолын хавсралт.

"АВТОБУС-3" КОМПАНИ / У.Ү.Г /-ын ДҮРЭМ.

Нэг.Ерөнхий зүйл

1. "Автобус-3" компани /У.Ү.Г/- нь төрийн өмчид тулгуурлан үйл ажиллагаа явуулах улсын үйлдвэрийн газар мөн.

2- "Автобус-3" компани /У.Ү.Г/-ын зорилго нь нийслэлийн хот орчмын үйлчилгээ,тасралтгүй ажиллагаатай үйлдвэрийн газрын шөнийн үйлчилгээ,зуны пионерийн зуслангийн үйлчилгээг бүрэн хангахад оршино.

3. Тус компани нь өөрийн үйл ажиллагаагаа явуулахын тулд банкинд харилцах данстай байхын хамт бусад төр,аж ахуйн байгууллага,хоршоолол,хувь хүмүүстэй биеэ даасан гэрээ хэлэлцээр хийж ажиллах хуулийн этгээд байна.

4. "Өвтобус-3" компани нь бүхий л үйл ажиллагаандаа хууль тогтоомж,сахилга дэг журмыг чанд сахин биелүүлж,өөрт олгогдсон эрхээ төрийн болон хамт олныхоо эрх ашиг сонирхолд нийцүүлэн ажиллана.

5."Автобус-3" компанийг татан буулгах,шинээр өөрчлөн зохион байгуулах асуудлыг Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа шийдвэрлэнэ.

6."АВТОБУС-3" компани нь улсын бүртгэлд бүртгүүлж Найрамдлын дүүргийн нутаг дэвсгэрт байрлана.

7."Автобус-3" компани нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, бичгийн хуудас,тушаал,албан бичгийн бланктай байж,нягтлан бодохын тайлан тэнцэл гаргаж байна.

Хоёр. Эд хөрөнгө

1."Автобус-3" компани нь /У.Ү.Г/-ын хөрөнгө нь үндсэн ба эргэлтийн хөрөнгө,санхүүгийн бусад нөөцөөс бүрдэнэ.Эд хөрөнгөө БНМАУ-ын хууль тогтоомж болон дүрэмд нийцүүлэн үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эзэмшин ашиглаж захиран зарцуулна.

2.Компанийн ажилчин,албан хаагч нь төрийн өмчийг эзний ёсоор хайрлан хамгаалах үүрэгтэй.Өмчийг үрэгдүүлсэн,бусад хэлбэрээр хохирол учруулсан гэм буруутанд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.Компанийн хөрөнгийг бүрдүүлэх эх үүсвэр нь ажил үйлчилгээний болон бусад үйл ажиллагаанаас олсон орлого,улсын төсвийн хөрөнгө,бүх төрлийн зээл,бусад эх үүсвэр байна.

Гурав.Үйлчилгээ,аж ахуйн үйл ажиллгааа.

I.Компани нь үйлчилгээ,аж ахуйн үйл ажиллагаагаа байгуулсан гэрээний үүргийн дагуу зорчигч тээврийн өөрийн өртгийг хямдруулах,эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн явуулна.

2.Компани нь автобусны үйлчилгээг батлагдсан чиглэл, маршрут,цагийн хуваарь графикийн дагуу явуулан үйлчилгээний жигд ажиллагааг хангана. Үйлчилгээний чиглэл,маршрут шинээр нээх,хаах,үйлчилгээг үр ашигтайгаар өөрчлөн зохион байгуулах саналаа боловсруулан удирдах дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх үүрэгтэй.

3.Компани нь автобусны үйлчилгээний талаар үйлчилж байгаа газар нутгийн хөдөлмөрчдийн эрэлт хэрэгцээг байнга судалж, тэдэнтэй өргөн харилцаатай ажиллана.

4.Компани нь өөрийн санхүүгийн нөөцийг хэмнэлттэйгээр зориулалтын дагуу зарцуулж,төрийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж,удирдах дээд байгууллагатайгаа байгуулсан гэрээгээ цаг хугацаанд нь дүгнэж ажиллана.

5.Компани нь нягтлан бодох анхан шатны болон дүн бүртгэлийг үнэн зөв хөтөлж,бүртгэл тооцооны ажилд дэвшилтэт арга барил,техник хэрэгсэл нэвтрүүлэн мэдээ тайлан тэнцэлийг батлагдсан маягтаар гаргаж зохих дээд байгууллагад өгч байна. Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон журмын дагуу явуулж байна.

6.Компани нь тогтоосон норм нормативыг үндэслэн техникийн засвар үйлчилгээний нарийвчилсан графикийн дагуу өөрийн хөдлөх бүрэлдэхүүнийг техникийн үйлчилгээнд оруулж,урсгал засварыг цаг хугацаанд нь шуурхай хийж байна.

7.Зорчигч тээврийн үйлчилгээнд онцгой амжилт гаргасан хүмүүст БНМАУ-ын Хөдөлмөрийн баатар болон бусад хүндэт цол, төрийн шагнал,одон медалиар шагнуулах саналаа дээд байгууллагад уламжилна.

8.Орчноо бохирдуулахгүй байх түүний бүх талын арга хэмжээг авна.

Дөрөв."Автобус-3" компанийн /У.Ү.Г/-ын эрх.

I.Хэрэгцээтэй түүхий эд материалыг зохих газраас нь авч түүний ашиглалт,зарцуулалтанд хяналт тавьж ажиллана.

2.Компани нь банкин дахь зарлагын дансаар ажилчин,албан хаагчдын цалин хөлс,шагнал урамшуулал олгох гүйлгээ хийх.

3.Ажилчин-албан хаагчдын эзэмшилд байгаа эд хогшлыг картаар зохих эзэдэд нь хариуцуулан хяналт тавина.

4.Компани нь хууль тогтоомжинд заасны дагуу ажил мэргэжил хослох буюу албан тушаал хавсран ажиллахыг зөвшөөрөх,онцгой тохиолдолд ажилчин албан хаагчдын хүсэлтийг харгалзан чөлөө олгох, нэг сарын цалингаас хэтрүүлэхгүйгээр урьдчилгаа олгох эрхтэй.

Тав.Удирдлага,зохион байгуулалт.

I.Компанийн захирлыг Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргаа,хотын тээврийн газар гэрээний үндсэн дээр томилно.

2.Захирал нь компанийн үйл ажлыг зохион байгуулж түүний үйл ажиллагааны үр дүнг бүрэн хариуцна. Захирал нь дээд шатны болон бусад газруудтай компанийг төлөөлөн харилцаж,түүхий эд,хэрэгслийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах,эрх хэмжээнийхээ дотор тушаал заавар гаргах,хөдөлмөрийн хуулийн дагуу ажилчин албан хаагчдыг ажилд авах,халах,тэдгээрийг шагнаж урамшуулах,тэтгэмж тусламж олгох,сахилга батын арга хэмжээ авах эрхтэй.

3.Компанийн захиргаа нь ҮЭ-ийн байгууллагатай хамтран хамтын гэрээ байгуулж,уг гэрээний үүргээ цаг тухайд нь биелүүлж ажиллана.

4.Компанийн захиргаа нь хөдөлмөрийн дотоод дүрмээ батлах өөрчлөх,шагнал болон нийгэм соёлын арга хэмжээний санг төлөвлөн батлах,түүнээс ажиллагсадыг шагнах,бусад хөнгөлөлт олгох эрхтэйгээр ажиллана.